



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 09 сарын 08 өдөр

Дугаар 426

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 148 дугаар тогтоолын 1.6 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1.2, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Хөвсгөл аймагт барьж, ашиглалтад оруулсан, нийт 3,188,820,674.00 (гурван тэрбум нэг зуун наян найман сая найман зуун хорин мянга зургаан зуун далан дөрвөн) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан "Шинэ мөрөн" орон сууцны шугам сүлжээний барилга байгууламжийг Хөвсгөл аймгийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, Хөвсгөл аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Б.Болд нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон үл хөдлөх хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авсан Улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтыг харгалзан, эзэмшигч байгууллагыг тогтоох асуудлыг шийдвэрлүүлэх;

2.2. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн
426 дугаар тогтоолын хавсралт

УЛСЫН ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТЭЭР БИЙ БОЛСОН ХӨВСГӨЛ АЙМГИЙН ОРОН НУТГИЙН
ӨМЧИД БҮРТГЭХ ХӨРӨНГӨ ("Шинэ мөрөн" орон сууцныг шугам сүлжээний
барилга байгууламж)-ИЙН ЖАГСААЛТ

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр	Гүйцэтгэлээрх хөрөнгийн дүн /төгрөг/	Улсын комиссын актын дугаар	Ашиглагч байгууллага
1	Гадна дулаан хангамж	1,072,382,595.00	УКД 2018.12.14	"Хөвсгөл-Ус суваг" ХХК
2	Гадна цэвэр ус	43,339,115.00		"Хөвсгөл-Ус суваг" ХХК
3	Гадна бохир ус	524,641,728.00		"Хөвсгөл-Ус суваг" ХХК
4	6 кВ-ын кабель шугам	437,113,897.00		"Хөвсгөл-эрчим хүч" ХХК
5	КТПН-ний 160 кВА - 10/0.4 кВ	31,897,177.00		"Хөвсгөл-эрчим хүч" ХХК
6	Дэд өртөө	630,298,767.00		"Хөвсгөл-эрчим хүч" ХХК
7	Бохир усны насос станцын барилга	113,110,190.00		"Хөвсгөл-Ус суваг" ХХК
8	УДДТөв	336,037,205.00		"Хөвсгөл-Ус суваг" ХХК
	Нийт дүн	3,188,820,674.00 (гурван тэрбум нэг зуун наян найман сая найман зуун хорин мянга зургаан зуун далан дөрвөн)		